



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 09 өдөр

Дугаар A/502

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын 350 жилийн “Түүх бүтээлцсэн он жилүүд” ном хэвлүүлэх зардалд 5 000 000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Ном хэвлүүлэхэд зарцуулагдах 5 000 000 төгрөг /таван сая /-ийг Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 5.2-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөшөөт хөгжил сангийн захирал /Т.Мягмардорж/, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ